



**ЖАГСААЛ ЦУГЛААНЫ
ЭСРЭГ ЦАГДААГИЙН ХҮЧИЙГ
ХЭРЭГЛЭХЭЭС ЗАЙЛСХИЙХ НЬ**

ХОНКОНГИЙН ЦАГДАА ХУУЛЬ БУС ХҮЧ ХЭРЭГЛЭСЭН НЬ

UIN.MN
СУДАЛГААНЫ САН

ЭМНЕСТИ
ИНТЕРНЭШНЛ



Эмнести Интернэшнл бол хүн бүр эрхээ эдэлдэг дэлхийн ертөнцийг бий болгохын төлөө 7 сая гаруй гишүүд, дэмжигчдийг эгнээндээ нэгтгэсэн даян дэлхийн хөдөлгөөн юм.

Хүний эрхийн түгээмэл тунхаглал болон хүний эрхийн олон улсын хэм хэмжээгээр хамгаалагдсан бүхий л эрхийг хүн бүрд эдлүүлэх нь бидний эрхэм зорилго билээ.

Бид төрийн засгийн аливаа байгууллага, улс төрийн үзэл хандлага, эдийн засгийн эрх ашиг болон шашны үзлээс бүрэн ангид, хараат бус байгууллага бөгөөд гишүүд дэмжигчид хийгээд олон нийтийн хандив, дэмжлэгээр санхүүждэг болно.

©Эмнести Интернэшнл 2019

Энэ сэтгүүлд тусгагдсан бүтээлүүд Бүтээлч Хамтын Өмчид харьяалагдана. (зохиогчийн нэрийг дурдана, худалдахгүй, хуулбарлахгүй, олон улсын 4.0 зөвшөөрөл)
<https://creativecommons.org/licenses/by-nc-nd/4.0/legalcode>

Дэлгэрэнгүй мэдээллийг манай цахим хуудсаас авна уу:
www.amnesty.org

Зохиогчийн эрхийг Эмнести Интернэшнл хэмээн заагаагүй тохиолдолд Бүтээлч Хамтын Өмчийн зөвшөөрөл олгохгүй.
2019 онд анхлан хэвлэгдэв.
Amnesty International Ltd
Ийстон Гудамж 1, Петер Бененсоны Ордон
Лондон хот WC1X 0DW, UK

Индекс: ASA 17/0576/2019

Эх хэвлэлийн хэл: Англи

amnesty.org



Cover photo: Hong Kong Police dispersing protestors.
© Jimmy Lam

UIN.MN
СУДАЛГААНЫ САН

ЭМНЕСТИ
ИНТЕРНЭШНЛ



АГУУЛГА

1. ТАНИЛЦУУЛГА	2
2. БОРООХОЙ БОЛОН ХУВАНЦАР СУМЫГ ХУУЛЬ БУСААР АШИГЛАСАН НЬ	5
3. ОЛОН ХҮНД НӨЛӨӨЛӨХ ТУСГАЙ ХЭРЭГСЛИЙГ ЗҮЙ БУСААР ХЭРЭГЛЭСЭН НЬ	9
4. ЦАГДААГИЙН АЛБАН ХААГЧИЙГ ТАНИХ БОЛОМЖГҮЙ БАЙДАЛ	13
5. СЭТГҮҮЛЧ БОЛОН ЭМНЭЛГИЙН ЯАРАЛТАЙ ТУСЛАМЖИЙГ ХЯЗГААРЛАСАН НЬ	14
6. ОЛОН УЛСЫН ХҮНИЙ ЭРХ ХЭМ ХЭМЖЭЭ	17
7. ЗӨВЛӨМЖ	19

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

1. ТАНИЛЦУУЛГА


Гэмт хэрэгт сэжиглэгдсэн иргэдийн гэм буруугийн асуудлыг БНХАУ-ын шүүхээр шийдвэрлүүлдэг байх Хонконгийн хууль тогтоох зөвлөлийн баталсан хуулийн нэмэлт, өөрчлөлтийг эсэргүүцэн 2019 оны 06 дугаар сарын 12-ны Лхагва гарагт хэдэн зуун мянган иргэд Хонконгийн улс төрийн амьдралын төв болсон гудамжнуудад тайван жагсаал цуглаан явуулсан билээ.

Энэ үеэр тайван жагсаал цуглаанд оролцсон үй олон жирийн иргэдийн эсрэг зайлшгүй шаардлага үүсээгүй байхад цагдаагийн хүч, албадлагыг хэтрүүлэн хэрэглэсэн, ялангуяа цагдаагийн тусгай хүчин, түүний тусгай бүлгийг ашигласан нь нэгэнт нийтэд илэрхий болсон юм.

Цагдаа нар жагсаал цуглааныг албадан тараах зорилгоор нулимс асгаруулагч хий, резин болон цацрагч хуванцар сумтай буу, нулимс асгаруулагч хий болон чинжүүт цацлага, бороохой зэргийг ашиглажээ. Хүний амь насанд хор хөнөөлгүй гэгдэх дээрх хэрэгсэл нь олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл хэдий ч хүний биед хүнд гэмтэл учруулах, тэр ч бүү хэл үхэлд хүргэх боломжтой байдаг. Эдгээр албадлагын тусгай хэрэгслийг зөвхөн хүчирхийллийг таслан зогсоох зорилгоор тусгай журмаар хэрэглэх бөгөөд тайван замаар жагсагчдын эсрэг ашиглахыг хориглосон байдаг. Тухайлбал, олон улсын хэм хэмжээний дагуу нулимс асгаруулагч хийг зөвхөн зайлшгүй шаардлага үүссэн үед олон нийтийг тараах зорилгоор хэрэглэхийг зөвшөөрдөг.

Эмнести Интернэшнл хүний эрхийн зөрчлийг баримтжуулсан хэд хэдэн дүрс, бичлэгийг цуглуулсан бөгөөд тэдгээрийн 20 орчим нь олон нийтийн хамарсан жагсаал цуглааны үеэр цагдаа нар хүч албадлагыг хэтрүүлэн хэрэглэсэн 14 тохиолдлыг баримтжуулжээ. Дээрх бичлэгүүдийг орон нутгийн болон олон улсын хэвлэл мэдээллийн хэрэгсэл, иргэний нийгмийн байгууллага, жирийн иргэд хийсэн бөгөөд олон нийтийн хэвлэл, олон нийтийн сүлжээгээр цацагдсан юм. Бид дээрх үйл явдлын талаарх холбогдох баримтуудыг ул суурьтай судалсны үндсэн дээр 6 дугаар сарын 12-ны өдөр зохион байгуулагдсан тайван жагсаалд оролцож байсан олон мянган иргэдийн эсрэг цагдаагийн албан хаагчид хүч албадлага хэрэгсэн нь олон улсын хүний эрхийн хэм хэмжээг зөрчсөн болохыг олж тогтоосон.

Хууль сахиулах байгууллага нь хүч албадлага хэрэглэхээс аль болох зайлсхийж, нөхцөл байдлыг хүндрэхээс сэргийлж холбогдох талуудтай уулзалт зохион байгуулан хэлэлцэн зөвшилцөх шаардлагатай байдаг. Дээрх үүрэг нь болзошгүй хүндрэл бэрхшээлээс урьдчилан сэргийлж буй хэрэг юм. Харин хүч албадлагыг хэтрүүлэн хэрэглэж, асуудалд үл тэвчсэн байдлаар хандаж байгаа цагдаагийн байгууллагын хандлага нь үүсээд байгаа нөхцөл байдлыг улам бүр хурцатгаж, зөрчилдөөн, дайсагнасан хандлагыг өдөөх эрсдэлтэй байна. Цагдаагийн байгууллагын асуудалд хэрхэн хандаж байгааг илтгэх гадаад хэлбэр (тухайлбал, ашиглаж байгаа хэрэгсэл, дайчлагдсан цагдаагийн тоо), илэрч байгаа хандлагууд нь нөхцөл байдлыг улам бүр хурцатгахаас зайлсхийсэн байвал зохино. Хэрэв хууль сахиулагчид хүч хэрэглэхэд хүрвэл энэ нь хуульд заасан үндэслэл бүрдсэн байх, зайлшгүй бөгөөд гарцаагүй байх, тохиромжит байдлаар хэрэглэх гэсэн хүний эрхийг хязгаарлах суурь зарчимд нийцсэн байх шаардлагатай.



Бид 06 дугаар сарын 12-ны өдрийн жагсаал цуглааны үеэр цагдаагийн хүч албадлагыг хэтрүүлэн хэрэглэсэн үйлдэлтэй холбогдуулан энэхүү бодит зураглалыг боловсруулсан.



СЭЖИГТЭН, ЯЛТНЫГ ШИЛЖҮҮЛЭХ ХУУЛИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ЭСРЭГ ЖАГСААЛ: ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

2019 оны 06 дугаар сарын 12-ны өдөр Хонконгийн засгийн газрын төв байрны ойролцоох гудамж талбайд сэжигтэн, ялтныг шилжүүлэх талаарх хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хүчингүй болгохыг шаардсан иргэдийн жагсаал өргөн олныг хамрах болсон. Энэхүү эсэргүүцлийн жагсаал нь 6 дугаар сарын 9-ний өдөр зохион байгуулагдсан, зохион байгуулагчдын мэдээлснээр 1.03 сая хүн оролцсон ижил шаардлага бүхий жагсаалын дараахан зохион байгуулагдсан билээ.

Хэрэв сэжигтэн, ялтныг шилжүүлэх хуулийн нэмэлт, өөрчлөлт хүчин төгөлдөр үйлчилж эхлэвэл Хонконгийн газар нутагт үйлдэгдсэн гэмт хэрэгт холбогдсон иргэдийг эх газрын Хятадын хяналтад шилжүүлэх юм. Ингэснээр шүүхийн системээр дамжуулан нийгмийн бодит дуу хоолой болсон бүлэг, тухайлбал хүний эрхийг хамгаалагчид, сэтгүүлчид, иргэний нийгмийн байгууллагын ажилтнууд хийгээд Хонконгод оршин суугаа хэн бүрд тавих эх газрын удирдлагын эрх мэдлийг өргөжүүлэхэд хүргэнэ.

Эх газрын Хятадын шүүхийн тогтолцоо нь цагдан хорих, эрүүдэн шүүх, болон бусад хүнлэг бус хэрцгий хандах, шударгаар шүүлгэх эрхийг ноцтойгоор зөрчих, хүчээр алга болгох болон шүүх хурал хийхгүйгээр иргэнийг цагдан хорих зэргээр хүний эрхийг ноцтойгоор зөрчдөг болохыг олон баримтаар баталгаажуулсан байдаг.¹

6 дугаар сарын 16-ны өдөр Хонконгийн гудамж талбайд дахин 2 сая орчим хүн тайван замаар жагссан бөгөөд тэд сэжигтэн, ялтныг шилжүүлэн өгөх талаарх хуулийн нэмэлт, өөрчлөлтийг эцэслэн хүчингүй болгох, түүнчлэн 6 дугаар сарын 12-ны зохион байгуулагдсан жагсаалд оролцогчдын эсрэг цагдаагийн хүчийг хэтрүүлэн хэрэглэсэн үйлдлийг нягтлан хянан үзэхийг шаардсан юм.

¹ Холбогдох жишээ баримтыг Эмнести Интернэшнл, Хятад: "Тэд хаана байна вэ?" (Индекс: ACA 17/9113/2018), www.amnesty.org/download/Documents/ASA1791132018ENGLISH.PDF; Эмнести Интернэшнл, Хятад дахь үхлийн нууцууд, эцэс төгсгөлгүй-Эрүүдэн шүүлт болон хэрэг тулган хүлээлгэлт (Индекс: ACA 17/2731/2015) www.amnesty.org/download/Documents/ASA1727312015ENGLISH.PDF



ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН МЭДЭЭЛСНЭЭР ТЭД ЗЭВСЭГ ХЭРЭГСЭЛ БОЛОН ТУСГАЙ АЛБАН ХААГЧДЫГ АШИГЛАСАН

Цагдаагийн комиссар Стэфэн Ло 6 дугаар сарын 13-ны өдөр хэвлэлийн бага хуралд хэлсэн үгэндээ цагдаа нар 150 орчим нулимс асгаруулагч хий, хэд хэдэн удаа резин сумтай буугаар буудаж, 20 удаа цацрагч хуванцар үрлэн сумтай буугаар буудсан хэмээн мэдэгджээ.²

Олон тооны дүрс бичлэг болон гэрэл зурагт авагдсанаар Хонконгийн “Рапорс” хэмээн нэрлэгдэх цагдаагийн тусгай хүчний бүлгийг жагсаал цуглааны үеэр ашигласан нь нотлогдсон. Тусгай хүчний бүлэг нь Хонконгийн цагдаагийн хүчний дэргэдэх тусгай хүчний нэгэн салаа юм. Гэвч цагдаагийн газраас 6 дугаар сарын 12-ны өдрийн жагсаалд хэчнээн тооны цагдаагийн албан хаагчийг дайчилсан тухай болон тэдгээрийн төрлийн талаарх мэдээллийг олон нийтэд мэдээлээгүй байна.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

² Крис Чэнг, “хэт хязгаарлалт” – Хонконгийн цагаа 150 орчим удаа нулимс асгаруулагч, 20 удаа цацрагч хуванцар үрлэн сумтай буугаар жагсагчдын эсрэг ашигласан, Хонконгийн чөлөөт хэвлэл, 2019 оны 6 дугаар сарын 13, www.hongkongfp.com/2019/06/13/just-restrained-hong-kong-police-say-150-round-tear-gas-20-bean-shots-fired-anti-extradition-law-riot/

2. БОРООХОЙ БОЛОН РЕЗИН СУМТАЙ БУУГ ХУУЛЬ БУСААР ХЭРЭГЛЭСЭН НЬ

Жирийн иргэний дүрсжүүлсэн энэхүү бичлэгт 6 дугаар сарын 12-ны өдөр зохион байгуулагдсан жагсаал, цуглааны үеэр хууль тогтоох зөвлөлийн ордны ойролцоох төв гудамж болох Харкорт болон Тим Ва-ийн өргөн чөлөөний уулзварт өдрийн цагаар хэсэг бүлэг цагдаагийн тусгай хүчний албан хаагчид тайван замаар жагсаал оролцсон иргэнийг бороохой ашиглан хэрцгийгээр цохиж байгааг харагдаж байна. Жагсаалд оролцогч иргэний хувьд тэрээр хүчирхийлэл, эсэргүүцлийн шинжтэй ямар нэгэн үйлдэл хийгээгүй байгаа нь илэрхий байгаа ч цагдаа нар түүнийг газарт дарж унагаасныхаа дараа ч бороохойгоор үргэлжлүүлэн цохисоор байжээ.



↑ Тусгай бүлгийн хэсэг бүлэг цагдаа нар ямар ч хүчирхийлэл, эсэргүүцэл үзүүлэхгүй байгаа тайван замаар жагсагчийг бороохой ашиглан хэрцгийгээр цохиж байгаа нь

Дээрх тохиолдолд бороохой ашигласан нь хууль тогтоомжийг илэрхий зөрчсөн үйлдэл юм. Учир нь цагдаа нар зайлшгүй шаардлага үүсээгүй байхад тохиромжгүй байдлаар хүч хэрэглэжээ. Хүний амь нас болон эрүүл мэндэд нь ноцтой аюул учруулахаас бусад тохиолдолд бороохойгоор хүний толгой, мөр болон бэлэг эрхтэн, нуруу зэрэг хүний биеийн эмзэг хэсгүүдэд цохиж болохгүй. Учир нь энэхүү нэг бүрийн тусгай хэрэгслийг ашиглах нь хүнийг үхэлд хүргэх, хүнд гэмтэл учруулах боломжтой. Бичлэгт харагдаж байгаагаар ямар ч шаардлагагүй байхад цагдаа нар жирийн жагсагчийн эсрэг хүч хэрэглэжээ. Хэрэв тухайн иргэн хүчирхийлэл үйлдсэн бол түүнийг цагдаагийн хүчнийхэн барьж зогсоосон л бол бороохой ашиглахаа тэр даруй зогсоох ёстой.

ЖАГСААЛ ЦУГЛААНЫ ЭСРЭГ ЦАГДААГИЙН ХҮЧИЙГ ХЭРЭГЛЭХЭЭС ЗАЙЛСХИЙХ НЬ
ХОНКОНГИЙН ЦАГДАА ХУУЛЬ БУС ХҮЧ ХЭРЭГЛЭСЭН НЬ

Эмнести Интернэшнл

Хонконгийн их сургуулийн оюутны холбооны телевизийн бичлэгт бичигдснээр 6 дугаар сарын 12-ны өдөр найм орчим тусгай хүчний цагдаагийн албан хаагчид хотын төвд байрлах Лунг Во гудамж дагуух явган хүний зам дээр жагсаалд оролцсон хүч дорой иргэнийг өдрийн цагаар бороохойгоор цохиж байна. Тухайн иргэн савтай ус бүхий уут гартаа барьсан байжээ.



 *Хэсэг бүлэг цагдаагийн тусгай хүчнийхэн гартаа савалсан устай уут барьсан иргэнийг бороохойгоор цохиж байгаа нь*

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Хонконг Аппл Дейли-гийн дүрсжүүлсэн бичлэгт 6 дугаар сарын 12-нд өдрийн цагаар цагдаа нар хууль тогтоох зөвлөлийн ордны гаднах талбайд жагсаал оролцсон нэгэн эмэгтэйд газарт унагааж, бороохой болон хамгаалалтын бамбайн ирмэгээр харгис хэрцгийгээр хэд хэдэн удаа цохиж байгаа нь авагджээ.



Хэсэг бүлэг цагдаа нар жагсаал оролцсон эмэгтэйд бороохой болон хамгаалалтын бамбайн ирмэгээр удаа дараалан цохиж байгаа нь

Бороохой бол хүний бие махбодод хүнд гэмтэл учруулах эрсдэлтэй хэрэгсэл бөгөөд ялангуяа толгойн хэсэгт цохисон бол тархины хүнд гэмтэл учруулах, нуруу, хүзүү болон хүний биеийн эмзэг хэсэгт цохисон бол үхэлд ч хүргэх аюултай. Зөвхөн хүчирхийллийг таслан зогсоох зорилгоор цагдаа нар бороохой ашиглаж болох бөгөөд харин тайван замаар жагсаалд оролцож байгаа иргэд төдийгүй, жагсаалыг хөндлөнгөөс ажиглаж байгаа иргэний эсрэг дээрх хэрэгслийг ашиглаж болохгүй. Цагдаа нарын жирийн иргэний эсрэг бороохой хэрэглэж байгаа түрэмгий, дээрэнгүй үйлдэл нь нөхцөл байдлыг улам хурцатгахыг үгүйсгэхгүй.

Цагдаагийн хамгаалалтын тусгай хэрэгсэл болох бамбайн ирмэгээр хүнийг цохих нь амь насанд хохирол учруулах эрсдэлтэй. Жагсагчдын эсрэг бамбайг зөвхөн хамгаалалт болгон хэрэглэх бөгөөд харин түүний ирмэгээр цохиж болохгүй.

TVB телевизийн мэдээгээр цацагдсан дараах бичлэгт Цагдаагийн тусгай хүчний нэгэн гишүүн 6 дугаар сарын 12-нд өдрийн цагаар Харкорт Роуд болон Коттон Три Драйв гудамжны уулзвар болон явган хүний зам дээр байгаа жагсагчид руу бидний таамаглаж байгаагаар резин сумтай буугаар буудаж байна. Бичлэгт авагдсанаар зарим жагсагчдын нүүр резин сумтай буунд өртжээ.



Тусгай хүчний нэгэн цагдаа жагсаалд оролцож байсан бөөгнөрсөн иргэдийн зүг бидний таамаглаж байгаагаар резин сумтай буугаар буудаж байна.

ЖАГСААЛ ЦУГЛААНЫ ЭСРЭГ ЦАГДААГИЙН ХҮЧИЙГ ХЭРЭГЛЭХЭЭС ЗАЙЛСХИЙХ НЬ

ХОНКОНГИЙН ЦАГДАА ХУУЛЬ БУС ХҮЧ ХЭРЭГЛЭСЭН НЬ

Эмнести Интернэшнл

Резин сумтай буугаар хүний толгой, нүүр, цээжин хэсэгт буудсан тохиолдолд маш хүнд гэмтэл учруулах эрсдэлтэй. Иймээс хүний биеийн эдгээр хэсгүүдэд резин сумтай буугаар буудаж болохгүй. Хууль сахиулагчид хүчирхийлэл үйлдэж байгаа иргэний эсрэг түүний үйлдлийг таслан зогсоох зорилгоор резин сумтай буугаар буудаж болох хэдий ч жагсаалд оролцогч жирийн иргэдийн зүг хэрхэвч буудаж болохгүй. Тиймээс хуран цугларсан олон хүний эсрэг, санамсаргүйгээр буудах нь хориотой бөгөөд гагцхүү тодорхой тохиолдолд тухайн нэг этгээд рүү буудахыг зөвшөөрдөг.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

3. ОЛОН ХҮНД НӨЛӨӨЛӨХ ТУСГАЙ ХЭРЭГСЛИЙГ ЗҮЙ БУСААР ХЭРЭГЛЭСЭН НЬ

2019 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн үдээс хойш жагсаал цуглаан болж байсан зарим газарт цагдаа болон жагсагчдын хоорондох сөргөлдөөнт харилцаа улам нэмэгдэж, цагдаа нар нулимс асгаруулагч хий ашиглаж эхэлснээр хүчирхийлэл даамжирлаа.

Иргэний баримтжуулсан энэхүү дүрс бичлэгээс үзэхэд 6 дугаар сарын 12-ны өдөр Конгконгийн хууль тогтоох зөвлөлийн ордны ойролцоох гудамжнуудад олон мянган жагсагчид цугларсан байх бөгөөд цагдаа нар Тим Ва өргөн чөлөөнд тайван замаар хуран цугларсан жагсагчдыг хүчээр тараах зорилгоор нулимс асгаруулагч хийгээр буудаж эхэлж байна. Жагсагчид амны хаалт, нүдний шил зүүж гартаа шүхэр барьжээ.



 *Цагдаа нар Тим Ва өргөн чөлөөнд тайван замаар хуран цугласан жагсагчдыг хүчээр тараах зорилгоор нулимс асгаруулагч хийгээр буудаж эхэлж байна.*

Эмнести Интернэшнлийн хийсэн дүн шинжилгээгээр мөн өдрийн орой Харкорт гудамжинд тайван замаар жагсаж байсан иргэдийн эсрэг цагдаа нар нулимс асгаруулагч хий ашиглажээ.


ЖАГСААЛ ЦУГЛААНЫ ЭСРЭГ ЦАГДААГИЙН ХҮЧИЙГ ХЭРЭГЛЭХЭЭС ЗАЙЛСХИЙХ НЬ

ХОНГОНГИЙН ЦАГДАА ХУУЛЬ БУС ХҮЧ ХЭРЭГЛЭСЭН НЬ

Эмнести Интернэшнл

Иргэний дүрсжүүлж, парламентын гишүүн Чу Хой Дикийн олон нийтэд түгээсэн доорх бичлэгт 6 дугаар сарын 12-ны өдрийн оройн 4 цагийн үед Адмирал СИТИК цамхагын гадаа хуран цугларсан жагсагчдын эсрэг цагдаа нар нулимс асгаруулагч хийгээр цэнэглэсэн буугаар хэдэн талаас нь буюу Лунг Ри гудамж болон парламентын ордны талаас буудаж эхэлжээ. Нулимс асгаруулагч хийнээс зугтааж дайжсан иргэд цагдаа нарт бүслэгдэн шахагдсанаас СИТИК ЦАМХАГ барилгын зүг зугтаажээ. Зугтаах өөр газар байхгүйгээс жагсагчдын зарим нь барилгын төв хаалгаар орохоор хичээж байсан бол үлдсэн хэсэг нь хамгаалалтын хашлагаар барилгын төв хаалгыг эвдэж орохоор оролдож байна. Учир нь барилгын төв таван хаалганы 2 нь түгжээтэй байжээ. Эмнести Интернэшлийн дүн шинжилгээ хийсэн өөр нэгэн бичлэгт барилгын гадаа цугларсан жагсагчдын бараг хажууд тэдний араас ойролцоогоор 9 удаа нулимс асгаруулагч хийгээр цэнэглэсэн буугаар бууджээ.



 [Ямар нэгэн зэвсэггүй хэдэн зуун жагсагчид цагдаа нарт бүслэгдсэн байх бөгөөд нулимс асгаруулагч хийнээс зугтааж Хууль тогтоох байгууллагын ордны эсрэг талд байрлах СИТИК ЦАМХАГ барилгын хаалгаар нэвтэрч орохоор оролдож байна.](#)

Нулимс асгаруулагч хийг зөвхөн хүчирхийлэл даамжирч газар авсан үед цугларсан олныг тараах зорилгоор хэрэглэнэ. Харин иргэд зугтаах боломжгүй, гарах, орох гарц нь хаагдсан, хязгаарлагдсан буюу шахагдсан газарт байрлаж байгаа үед дээрх тусгай хэрэгслийг хэзээ ч ашиглаж болохгүй. Нулимс асгаруулагч хийгээр цэнэглэсэн буу, эсхүл цацлагыг хүн рүү шууд чиглүүлсэн буудах, шүрших эсхүл нэг газарт богино хугацаанд хэд хэдэн удаа хэрэглэхийг мөн хориглодог. Хамгийн чухал нь хууль сахиулагчид нулимс асгаруулагч хий ашиглах талаарх мэдэгдлийг иргэдэд сонсогдохуйц байдлаар урьдчилан мэгдэж тухайн газрыг сайн дураар орхин явах боломжит хугацаагаар хангах ёстой.


Хонконг Аппл Дейлигийн баримтжуулсан дүрс бичлэгт 6 дугаар сарын 12-нд өдрийн цагаар хамгаалалтын дуулга өмссөн нэгэн цагдаагийн албан хаагч Лунг Во гудамжинд байрлах цэцгийн мандлын чулуун хашлага дээр ганцаараа сууж байгаа, ямар нэгэн хариу эсэргүүцэл үзүүлээгүй иргэний нүүр рүү нулимс асгаруулагч шингэнийг 14 удаа цацаж байжээ. Энэхүү нулимс асгаруулагч шингэнийг энгийн номхон иргэний эсрэг хэрэглэх ямар ч шаардлага үүсээгүй байгаа нь тухайн бичлэгээс маш тодорхой харагдана.



 *Нэгэн хамгаалалтын дүүлгэ өмссөн цагдаа ямар ч эсэргүүцэл үзүүлээгүй энгийн иргэний нүүр рүү нулимс асгаруулагч шингэнийг шүршиж байгаа нь*

hkpeanuts.com сайтад байршуулсан доорх дүрс бичлэгт 6 дугаар сарын 12-ны өдөр газар доорх метроны буудлын гарах гарцыг хааж зогсох тусгай хамгаалалтын хэсэг бүлэг цагдаа нар гарах гарц нь бараг бүрэн хязгаарлагдсан жагсагчдын зүг нулимс асгаруулагч шингэнийг хэд хэдэн удаагийн давтамжтайгаар шүршжээ. Энэхүү нөхцөл байдал Харкорт паркийн ойролцоох газар доорх метроны буудлын E1 болон E2 гарц орчмыг бүхэлд нь хамарчээ. Цагдаагийн эсрэг ямар нэг эсэргүүцэл үзүүлээгүй цагаан хувцас өмссөн залуугийн бараг чанх урдаас цагдаа нар нулимс асгаруулагч шингэн цацаж байна.



 *Газар доорх метроны буудлын гарах гарцыг бүхэлд нь хааж зогссон тусгай хамгаалалтын хэсэг бүлэг цагдаа нар зугтаах газаргүй болсон жагсагчдын эсрэг олон удаагийн давтамжтайгаар нулимс асгаруулагч шингэн шүршиж байна.*

Гар аргаар шүрших химийн бодис бүхий нулимс асгаруулагчийг нийгмийн хэв журмыг ноцтойгоор зөрчиж, хүний амь нас болон эрүүл мэнд, түүнчлэн цагдаагийн албан хаагчийн эсрэг халдан довтолж байгаа иргэний хууль бус үйлдлийг зогсоох зорилгоор хэрэглэж болох хэдий ч тайван замаар хуран цугларсан олон нийтийн тараах зорилгоор хэрэглэх нь тохиромжгүй хэмээн үздэг. Хэрэв хэрэглэх

ЖАГСААЛ ЦУГЛААНЫ ЭСРЭГ ЦАГДААГИЙН ХҮЧИЙГ ХЭРЭГЛЭХЭЭС ЗАЙЛСХИЙХ НЬ

ХОНКОНГИЙН ЦАГДАА ХУУЛЬ БУС ХҮЧ ХЭРЭГЛЭСЭН НЬ

Эмнести Интернэшнл

зайлшгүй шаардлагатай бол энэхүү химийн бодисыг олон удаагийн давтамжтайгаар, эсхүл удаан хугацааны турш хэрэглэхээс зайлсхийх шаардлагатай. Түүнчлэн иргэний эсрэг нэг метрээс ойр зайд шүрших, гавлагдсан болон буланд шахагдан гарах гарцгүй болсон хүнд хэрэглэхийг хориглодог. Өөрөөр хэлбэл дээрх тусгай хамгаалалтын аргыг зөвхөн зугтаах боломж нь нээлттэй байгаа орчинд хэрэглэнэ. Харин ямар нэгэн газраас гарах, зугтаах боломж нь хязгаарлагдсан, хашигдсан орчинд байгаа иргэний эсрэг хэрэглэж хэрхэвч болохгүй. Хууль сахиулагчид хууль сахиулах үйл ажиллагаанд нь үр нөлөөтэй гэж үзвэл хэрэглэх зорилгодоо нийцүүлэн химийн тунг хамгийн бага хэмжээнд хэрэглэх шаардлагатай.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

4. ЦАГДААГИЙН АЛБАН ХААГЧИЙГ ТАНИХ, ТОДОРХОЙЛОХ БОЛОМЖГҮЙ БАЙДАЛ

TVB мэдээ, жирийн иргэд, Арилжааны Радио Мэдээ болон РТХК мэдээ зэрэг мэдээллийн дөрвөн эх сурвалжийн бэхжүүлсэн дүрс бичлэгт 6 дугаар сарын 12-ны өдрийн жагсаал цуглааны үеэр ажилласан тусгай албаны цагдаагийн ажилтнууд тусгай дугаар, нэр бүхий тэмдэг зүүгээгүй гурван тохиолдол тэмдэглэгджээ. Аюулгүй байдал хариуцсан төрийн нарийн бичгийн дарга Жон Ли Качиун 6 дугаар сарын 19-ний өдөр Хууль тогтоох зөвлөлийн хуралд өгсөн тайлбартаа Тусгай албаны цагдаагийн дүрэмд хувцсанд албан хаагчийг тодорхойлох дугаар болон нэрийг байршуулах газар байхгүй гэжээ.

Олон нийттэй харилцаж байгаа хууль сахиулах байгууллагын албан хаагчид нь өөрийн хэрэгжүүлсэн үйлдэл, үйл ажиллагааныхаа хариуцлагыг бүрэн хүлээхийн тулд өөрийн нэр, тусгай дугаартай байх шаардлагатай.

UIN.MN
СУДАЛГААНЫ САН

5. СЭТГҮҮЛЧ БОЛОН ЭМНЭЛГИЙН ЯАРАЛТАЙ ТУСЛАМЖИЙГ ХЯЗГААРЛАСАН НЬ

Арилжааны Радио Мэдээ болон РТХК Мэдээгээр цацагдсан дараах бичлэгт 6 дугаар сарын 12-ны өдрийн шөнө гадаа гудамжинд үүрэгт ажлаа гүйцэтгэж байсан сэтгүүлчийг явуулах зорилгоор цагдаа нар бороохойгоор цохиж байна. Сэтгүүлч өөрийн ажлын үнэмлэхийг үзүүлсэн хэдий ч цагдаа түүний эсрэг хүч албадлага үргэлжлүүлэн хэрэглэсээр байжээ.



  Нэр болон бүртгэлийн дугаар нь үл мэдэгдэх Цагдаагийн тусгай хүчний нэгэн цагдаа үүрэгт ажлаа гүйцэтгэж байгаа сэтгүүлчийг мэргэжлийн үнэмлэхээ үзүүлснийг эс харгалзан бороохойгоор цохиж байна.

ЖАГСААЛ ЦУГЛААНЫ ЭСРЭГ ЦАГДААГИЙН ХҮЧИЙГ ХЭРЭГЛЭХЭЭС ЗАЙЛСХИЙХ НЬ
ХОНКОНГИЙН ЦАГДАА ХУУЛЬ БУС ХҮЧ ХЭРЭГЛЭСЭН НЬ
Эмнести Интернэшнл

НОВ ТВ-ийн бичлэгт 6 дугаар сарын 12-нд өдрийн цагаар олон тооны тусгай албаны цагдаагийн бие бүрэлдэхүүн Ванчай болон Харкорд гудамж руу тусгай дуут дохио болон гэрэл асаасан түргэн тусламжийн машиныг нэвтрүүлэхгүй саатуулжээ. Гэвч жагсагчид хурдан хугацаанд зам тавьж өгсний үр дүнд түргэн тусламжийн тэрэг эсрэг талд байрлах өөр нэгэн замаар явжээ.



 [Цагдаагийн тусгай хүчнийхэн тусгай дуут дохио асаасан түргэн тусламжийн тэрэгний явах замыг хаажээ.](#)

Иргэд бүх нийтийг хамарсан жагсаал цуглаан болох газар болон түүнийг хэрхэн өрнөж байгаа талаарх мэдээллийг авах эрхтэй. Иргэний жагсаал цуглаанд оролцон, хуран цуглан эрхээ хэрэгжүүлэх, холбогдох хууль сахиулах байгууллагын ажилтнуудыг хариуцлагыг дээшлүүлэхэд хараат бус хэвлэл мэдээллийн хэрэгсэл, иргэний нийгмийн байгууллагын дүн шинжилгээ нь чухал нөлөө үзүүлдэг. Сэтгүүлч болон бусад байгууллагын зүгээс жагсаал цуглааныг ажиглах явцад Хууль сахиулах байгууллага хөндлөнгөөс саад учруулахгүй байж, харин ч тэдний үйл ажиллагаанд хүндэтгэлтэй хандаж, дэмжлэг үзүүлэх, зарим тохиолдолд тэдний аюулгүй байдлыг хангах хэрэгтэй. Түүнчлэн тэд жагсаал цуглааны үеэр бэртэж гэмтсэн иргэдэд түргэн тусламж үзүүлж байгаа эмнэлгийн байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх үүрэгтэй.



БЭРТЭЛ ГЭМТЭЛ

Эмнэлгийн байгууллагын захиргааны мэдээлснээр 6 дугаар сарын 13-ны өдрийн шөнийн 22 цагийн байдлаар улсын нийт 10 эмнэлэгийн түргэн тусламжийн тасагт жагсаал цуглаантай холбоотой 81 иргэн эмнэлгийн туслалцаа, үйлчилгээ авчээ.³ Нийт 22 цагдаагийн албан хаагч жагсаал, цуглааны үеэр бэртэж гэмтжээ.⁴

Хонконгийн Хууль тогтоох зөвлөлийн гишүүн, эмч Пиэрэ Чан эмнэлэгт баривчлагдсан иргэдийн талаарх мэдээг уншсаны дараагаар хэвлүүлсэн нийтлэлдээ цагдаагийн байгууллагад өгөх өвчтөний мэдээллийн талаар онцлон бичжээ.⁵ Ингэхдээ цагдаад баригдахаас айж эмээснээс үүдэн улсын эмнэлэг рүү явж чадаагүй бэртэж гэмтсэн жагсагчдын талаарх зарим мэдээллийг тусгажээ.⁶

³ Хонконгийн засаг захиргааны онцгой бүсийн Засгийн газар, “Эмнэлэгийн захиргааны албан бус тайлбар”, 2019 оны 06 дугаар сарын 13, www.info.gov.hk/gia/general/201906/13/P2019061301082.htm

⁴ Хонконгийн засаг захиргааны онцгой бүсийн Засгийн газар, “Цагдаа нар бослогыг зогсоох холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн”, хэвлэлийн мэдээ, 2019 оны 06 дугаар сарын 13, www.info.gov.hk/gia/general/201906/13/P2019061301029.htm?fontSize=1

⁵ Крис Чэнг, “Цагдаагийн байгууллага эмнэлэгээр үйлчлүүлсэн жагсагчидтай холбоотой бүхий мэдээллийг авах боломжтой хэмээн жагсаалд оролцсон иргэдийг эмнэлэгээс баривчилсаны дараа эрүүл мэндийн салбарын хууль тогтоогчид хэлжээ.”, Хонконгийн чөлөөт хэвлэл, 2019 оны 06 дугаар сарын 17, www.hongkongfb.com/2019/06/17/police-can-access-full-details-injured-protesters-hospital-says-medical-sector-lawmaker-following-patient-arrests/

⁶ “Бэртэж гэмтсэн иргэд цусаар шээж байсан ч эмнэлэгийн тусламж авахаас цааргалж байна. Улсын эмнэлэгийн эмч Вонг Ям-Хонг жагсаалын үеэр гэмтсэн иргэдийг эмнэлэгийн тусламж авахыг зөвлөж байна” Синг Тао өдөр тутмын сонин, 2019 оны 06 дугаар сарын 18, bit.ly/2L4cWEn



БАРИВЧИЛГАА

Хэвлэлийн мэдээлэлд бичсэнээр 6 дугаар сарын 17-ны байдлаар жагсаал цуглаантай холбогдуулан нийт 32 иргэнийг баривчилсан бөгөөд эдгээрээс 5 нь үймээн самуун өдүүлсэн хэргээр, 10 нь хүчирхийлэл, хууль бусаар жагсан, цагдаагийн эсрэг хүч хэрэглэсэн гэмт хэрэгт сэжиглэгджээ.⁷ 6 дугаар сарын 19-нд цагдаа нар 7 эрэгтэй, 1 эмэгтэйд хууль зөрчихөөр завдсан хэргээр шийтгэл ногдуулжээ.⁸

Цагдаагийн комиссар Стэфэн Ло 6 дугаар сарын 12-ны өдрийн жагсаал нь эцэстээ “бослого” болон хувирсан хэмээн мэдэгдсэн⁹ бол Хонконгийн захирагч Кэрри Лам олон нийтийн онцлоод байгаа дүрс бичлэгт харагдаж байгаачлан энэ бол жагсаал биш харин урьдчилан төлөвлөж зохион байгуулсан бослого хэмээн нэрлэжээ.¹⁰ Стэфэн Ло болон Кэрри Лам нар хожим дахин мэдэгдэхдээ дээрх бослогод идэвхийлэн оролцсон иргэдэд хуулийн хариуцлага ногдуулна гэжээ.¹¹

Нийгмийн дэг журмын талаарх Хонконгийн хуулийн 19 дүгээр зүйлд хууль бусаар зохион байгуулсан жагсаал, бослогод оролцсон хүмүүсийг хууль бусаар жагссан хэмээн үзэхээр хуульчилсан. Хэдийгээр 6 дугаар сарын 12-нд зохион байгуулсан жагсаалын үеэр зарим жагсагчид бослоготой холбоотой гэмт хэрэг үйлдсэн хэмээн мэдэгдээд байгаа ч уг жагсаалд оролцсон жирийн иргэдийн хувьд дээрх хуулийн дагуу хариуцлагад татагдах эрсдэлтэй юм.

UIN.MN
СУДАЛГААНЫ САН

⁷ Крис Чэнг, “хэт хязгаарлалт” — Хонконгийн цагаа 150 орчим удаа нулимс асгаруулагч, 20 удаа цацрагч хуванцар үрлэн сумтай буугаар жагсагчдын эсрэг ашигласан, Хонконгийн чөлөөт хэвлэл, 2019 оны 6 дугаар сарын 13, www.hongkongfp.com/2019/06/13/just-restrained-hong-kong-police-say-150-round-tear-gas-20-bean-shots-fired-anti-extradition-law-riot/

⁸ Ханг-Чанг Нг болон Лок Кей Сам, “Хуулийн дагуу хүнд шийтгэл ногдуулвал зохих тоосго, төмөрөөр зэвсэглсэн Хонконгийн бослогын эсрэг цагдаа нарын хамгаалалт”, Өмнөд Хятадын Өглөөний мэдээ, 2019 оны 06 дугаар сарын 17, www.scmp.com/news/hong-kong/law-and-crime/article/3041914/police-back-down-categorisation-hong-kong-protests

⁹ Шансан Као болон Чию Лу, “Сэжигтэн шилжүүлэх талаарх хуулийн төслийн эсрэг жагсаал бол хууль бус үйлдлийг өдүүлсэн бослого хэмээн Хонконгийн цагдаа дарга мэдэгдлээ”, Өмнөд Хятадын Өглөөний мэдээ, 2019 оны 6 дугаар сарын 13, www.scmp.com/video/scmp-originals/3014288/hong-kong-police-chief-declares-anti-extradition-bill-protest-riot

¹⁰ “Хуулийн төслийг эсэргүүцэн жагсагчид: Кэрри Лам ард түмнээсээ бүү урав”, ejinsigh.com, 2019 оны 6 дугаар сарын 13, www.ejinsigh.com/20190613-extradition-bill-protest-lam-slam-rioting-says-no-betrayal/

¹¹ Тони Чионг, Виктор Тинг, Жэффи Лам, “Хонконгийн цагдаагийн газрын дарга Стэфэн захирагч Кэрри Ламын тодорхойлсонлон цагдаа нар бослогыг хамгийн бага хохиролтойгоор зохицуулж чадлаа”, Өмнөд Хятадын Өглөөний мэдээ, 2019 оны 06 дугаар сарын 18, www.scmp.com/news/hong-kong/politics/articles/3014932/hong-kong-police-chief-stephen-lo-steps-back-riot-label; Алвин Лам болон Кристи Лянью “Ямар тохиолдолд бослого гэж үзэхгүй вэ?, Кэрри Ламын сүүлийн мэдэгдэл олон нийтийн дургүйцлийг хүргэж байна”, Өмнөд Хятадын Өглөөний мэдээ, 2018 оны 6 дугаар сарын 19, www.scmp.com/news/hong-kong/politics/article/3015061/when-riot-noyt-riot-carrie-lams-latest-attempt-pacify-hong

6. ХҮНИЙ ЭРХИЙН ТАЛААРХ ОЛОН УЛСЫН ЕРӨНХИЙ ХЭМ ХЭМЖЭЭ

Галт зэвсэг болон болон хүч хэрэглэх талаарх НҮБ-ын Үндсэн Зарчим болон бусад олон улсын хэм хэмжээнд заасны дагуу хууль сахиулагчид зөвхөн хүчирхийллийн бус аргаар асуудлыг үр нөлөөтэй шийдвэрлэх боломжгүй нөхцөлд хүчирхийлэл үйлдэгчийн хууль бус үйлдлийг таслан зогсоох зорилгоор хүч, албадлага хэрэглэнэ. Түүнчлэн хууль сахиулагчдыг хүний амь насанд аль болох хохирол учруулахгүй аргыг нэвтрүүлэх, уламжлал хэрэглэж байсан олон хувилбарт аргуудыг хэрэглэх, тулгарч байгаа асуудлын хир хэмжээнд тохируулан хүч албадлага хэрэглэх механизмыг бий болгохыг гишүүн улс орны төр засгийн газарт зөвлөдөг.

Хууль сахиулагчид жагсаал цуглааны үеэр жагсагчдыг өөрсдийн шууд удирдлага, хараа хяналтад байлгахыг эрмэлзэх, эсхүл жагсагчдад биеийн хүч хэрэглэх замаар тэдний зугтаах болон тэсэн тэвчих чадамжийг алдагдуулах зэргээр хүч хэрэглэх нь ямар ч тохиолдолд тэдний үйл ажиллагааны хууль ёсны зорилготой нийцэхгүй бөгөөд хүчирхийллийг улам бүр нөхцөлдүүлэг хэмээн Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг Тусгай илтгэгч мэдэгдээд:

Дээрх тохиолдолд иргэдийн бие махбодод өвчин, зовлон шаналал үзүүлж байгаа нь холбогдох олон улсын гэрээ, конвенцод тодорхойлсны дагуу эрүүдэн шүүх, болон бусад хэлбэрээр хүнлэг бус, доромжлон хандаж, шийтгэж байгаа үйлдэл бөгөөд зорилго, сэдлийн хувьд хууль ёсонд нийцэхгүй. Хохирогчийн сул дорой байдал, чадамжийг үл харгалзан түүний эсрэг бие махбодын шаналган зовоох үйлдлийг санаатай үйлдэх нь эрүү шүүлтийн хамгийн түгээмэл хэлбэр бөгөөд хүний эрхэм чанарыг алдагдуулж буй хэрэг юм. Тиймээс олон улсын гэрээнд заасан эрүүдэн шүүхийн талаар тодорхойлолтод үндэслэн ямар нэгэн нэмэлт бүрэлдэхүүн тусгайлан шаардахгүйгээр тодорхой нэг зорилгын хүрээнд аливаа сур дорой иргэнд бие махбодын өвчин, шаналал учруулах зорилгоор гуравдагч этгээдийн хүчийг ашиглах нь эрүүдэн шүүх, бусад хэлбэрээр хүнлэг бусаар нэр төрийн доромжлон харьцах, шийтгэх үйлдлийн ноцтой хэлбэр бөгөөд хууль ёсны зорилготой үл нийцэх юм гэжээ.¹²

Хэрэв жагсагчдын эсрэг хүч хэрэглэх бол энэ нь тухайн нөхцөл байдалд нийцсэн, тэдний үйлдэлд тохирсон байх шаардлагатай. Юуны өмнө хүч албадлагыг хүчирхийлэл үйлдэж байгаа этгээд рүү шууд чиглүүлэх бөгөөд хүчирхийлэл үйлдэгчийн олон хүнийг эсрэг чиглэсэн хууль бус үйлдлийг тухайн нөхцөл байдалд тохируулан таслан зогсоох боломжгүй болсон нөхцөлд хүч, албадлагыг ялгамжгүйгээр хэрэглэснийг зөвтөх боломжтой. Хүний амь насанд аюулгүй тусгай хэрэгсэл болох зэвсгийг ашигласнаас олон нийтэд үүссэн хор уршгийн хэмжээ нь хүчирхийллийн бус аргаар хүрч болох үр дүнгээс бага байвал тухайн хүч хэрэглэсэн үйлдлийг хууль бус бөгөөд хэтрүүлэн хэрэглэсэн хэмээн үзнэ.

¹² Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцах шийтгэх асуудлаарх НҮБ-ын тусгай илтгэгийн тайлан: Гуравдагч этгээдийн нэмэлт хүчийг ашиглах нь эрүүдэн шүүх, бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүнийг нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцийг зөрсөн үйлдэл, НҮБ-ын баримт, А/72/178 (2017), 47 дахь догол мөр

Гэхдээ цагдаа нар хүч хэрэглэсэн эсэргүүцэлтэй тулгарахгүй байхын тулд үлэмж хохирол учруулахаар хүч, албадлага хэрэглэхээс зайлсхийх боломжтой. Учир нь иргэд, олон нийтийн эсрэг хэрэглэх аливаа ч хүч, албадлага нь тухайн нөхцөл байдлаас хамааран хүний амь насыг хохироох болон бусад ноцтой үр дагаварт хүргэх эрсдэлтэй байдаг. Ийм учраас “хүний амь насанд хохиролгүй” гэгдэх тусгай хэрэгслийг хэрэглэх ньтохирмжгүй бөгөөд эрсдэлийг нэмэгдүүлдэг хэмээн бид үздэг. Хүний амь насыг хамгаалах зарчим нь хуулийг албадан хэрэгжүүлэх үйл ажиллагаанд баримтлал зохих үндсэн зарчим учир хууль сахиулагчид хамгийн бага хор уршиг учруулахаар арга хэрэгслийг эрэлхийлэх шаардлагатай.

Химийн хүнд элемент бүхий олон нийтэд нөлөөлөх тусгай хэрэгслийн үйлчлэл нь хүнийг үхэлд хүргэх өндөр эрсдэлтэй. Дээрх тусгай хэрэгслийг олон нийтийг хамарсан жагсаалын үеэр ашиглах нь хүчирхийлэл үйлдэгч болон тайван замаар жагсагч, түүнчлэн жагсаалыг хөндлөнгөөс ажиглаж байгаа жирийн иргэдийг ялгахгүйгээр нэгэн адил нөлөөлнө. Түүнчлэн иргэд гэнэт үймж сандарснаас үүдэн бусад ноцтой үр дагавар үүсэж болохыг сайтар бодолцох хэрэгтэй. Тиймээс хууль сахиулагчид хүчирхийлэл үйлдэгчдийн үйлдлийг өөр арга хэрэгслээр таслан зогсоох боломжгүй болсон нөхцөлд зөвхөн олон нийтийн тараах зорилгоор дээрх химийн бодис бүхий тусгай хэрэгслийг маш болгоомжтой хэрэглэх шаардлагатай. Дахин хэлэхэд олон нийтэд нөлөөлөх тусгай хэрэгслийг хэтрүүлэн хэрэглэх нь тайван замаар жагсагч хийгээд жирийн олон нийтэд ямар нэг ялгаваргүйгээр хохирол учруулна.

Кинетикийн үүднээс авч үзвэл резин сумаар цэнэглэсэн буу хэрэглэх нь үлэмж зохисгүй бөгөөд хүний биеийн толгой, нүүн болон цээжинд туссан нөхцөлд хүний биед хүнд гэмтэл учруулах, тэр бүү хэл үхэлд хүргэх аюултай. Тиймээс дээрх нэг бүрийн тусгай хэрэгслийг зөвхөн хүчирхийлэл үйлдэж байгаа этгээдэд хэрэглэх бөгөөд жагсагчид, олон нийтэд чиглүүлэн буудахыг хориглодог. Рекин сумаар цэнэглэсэн буу болон хуванцар цацрагч үрлэн сумтай буу нь хүний биед хүнд гэмтэл учруулдаг болохыг харгалзан үзэж хор уршигийг багасгах зорилгоор зөвхөн хүний биеийн доод хэсэгт чиглүүлэн буудна.

Холбогдох дүрэм, журмын дагуу цагдаа нар дээрх нэг бүрийн тусгай хэрэгслийг хэрэглэх гэж байгаа талаар зөрчил үйлдэж байгаа этгээдэд урьдчилан анхааруулж, хууль бус үйлдлээ зогсоох боломж олгох ёстой.

UIN.MN
СУДАЛГААНЫ САН

7. ЗӨВЛӨМЖ

Эмнести Интернэшнл Хонконгийн засгийн газраас тайван замаар жагсагчдын эсрэг дээрх хүч хэрэглэсэн үйлдлийг дахин гаргахгүй байж иргэний үзэл бодлоо илэрхийлэх, тайван замаар эвлэлдэн нэгдэх, хуран цуглах эрх чөлөөгөө эдэлж хэрэгжүүлэх нөхцлийг баталгааг хангахыг шаардаж байна.

Нэн ялангуяа, Хонконгийн Засгийн газар нь

- Жагсаал цуглааны үеэр цагдаагийн хүчийг ашиглах нь иргэдийн тайван замаар эвлэлдэн нэгдэх, хуран цуглах эрхээ хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, баталгаажуулахад чиглэх бөгөөд хүчирхийлэл даамжрах, хүндрэл бэрхшээл үүссэн үед дэмжлэг үзүүлэхэд чиглэдэг гэсэн зөв хандлагыг бүрдүүлэхэд анхаарах
- Цагдаагийн хүчний бие бүрэлдэхүүнийг хэт олон тоогоор дайчлах, жагсаал цуглааныг хүчээр талаарх хэт нүсэр хэрэгслийг ашиглах нь олон нийтийн эсэргүүцэл, дургүйцлийг нэмэгдүүлэх, хүчирхийллийн улам өдөөх болохыг анхаарч, цаашид дэмжлэг үзүүлэх хандлагыг ашиглах
- Жагсаал цуглааны үеэр хууль сахиулагчид хүч, албадлага хэрэглэх, ялангуяа жагсаал цуглааныг хүчээр тараах шийдвэр нь асуудлыг өөр арга замаар шийдвэрлэх боломжгүй нөхцөлд, хүний эрхийг хязгаарлахад баримтлах үндсэн зарчим болох зайлшгүй нөхцөлд, тохиромжит байдлаар хэрэглэх хэм хэмжээнд нийцэж байгаа нөхцөлд хэрэглэх болохыг санаж, жагсаал цуглааныг хүч хэрэглэн тараах нь хууль бус болохыг үндэсний хууль тогтоомжоор баталгаажуулах
- Хууль сахиулагчдын хүч, албадлага хэрэглэх талаарх харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомж нь олон улсын хууль, хэм хэмжээ, тухайлбал Хууль сахиулагчид зэвсэг, хүч хэрэглэх талаарх НҮБ-ын үндсэн зарчимд нийцэж байгаа эсэхийг дахин эргэн харах, түүнчлэн хууль сахиулагчдыг дээрх агуулгын хүрээнд зохих сургалтад хамруулах
- Жагсаал цуглааны үеэр ажиллаж буй хууль сахиулагчдыг шууд таних, тодорхойлох боломжийг бүрдүүлэх, тухайлбал нэр болон тусгай дугаар бүхий тэмдэгтэй болгох
- 6 дугаар сарын 12-нд цагдаа нарын хэрэглэсэн хүч албадлага, тэр дундаа нулимс асгаруулагч, резин сумаар цэнэглэсэн буу, бороохой, нулимс асгаруулагч хий, чинжүүт цацлага зэргийг хэрэглэсэн үйлдлийг шалгах хараат бус, хөндлөнгийн, үр нөлөөтэй, зохих мөрдөн шалгах ажиллагааг явуулах
- Хууль бусаар хүч албадлага хэрэглэсэн хууль сахиулах байгууллагын холбогдох эрх бүхий этгээд, ялангуяа удирдах албан тушаалтнуудад хариуцлага ногдуулах

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

ЖАГСААЛ ЦУГЛААНЫ ЭСРЭГ ЦАГДААГИЙН ХҮЧИЙГ ХЭРЭГЛЭХЭЭС ЗАЙЛСХИЙХ НЬ

ХОНКОНГ ЦАГДААГИЙН ХҮЧИЙГ ХУУЛЬ БУСААР АШИГЛАСАН НЬ

Эмнести Интернэшнл 2019 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн олон нийтийн хамарсан жагсаал цуглааны үеэр цагдаа нар хүний эрхийн зөрчиж байгааг баримтжуулсан хэд хэдэн дүрс, бичлэгийг цуглуулсан бөгөөд тэдгээрийн 20 орчим нь цагдаа нар хүч албадлагыг хэтрүүлэн хэрэглэсэн 14 тохиолдлыг баримтжуулжээ. Дээрх бичлэгүүдийг орон нутгийн болон олон улсын хэвлэл мэдээллийн хэрэгсэл, иргэний нийгмийн байгууллага, жирийн иргэд хийсэн бөгөөд олон нийтийн хэвлэл, олон нийтийн сүлжээгээр цацагдсан юм. Бид дээрх үйл явдлын талаарх холбогдох баримтуудыг ул суурьтай судалсны үндсэн дээр тайван жагсаалд оролцож байсан олон мянган иргэдийн эсрэг цагдаагийн албан хаагчид хүч, албадлага хэрэглэсэн Хонконгийн хууль сахиулагчдын үйлдэл нь олон улсын хүний эрхийн хэм хэмжээг зөрчсөн болохыг тогтоосон.

UIN.MN
СУДАЛГААНЫ САН

ИНДЕКС: ASA 17/0576/2019

2019 ОНЫ 6 САР

ХЭЛ: АНГЛИ

amnesty.org

ЭМНЕСТИ
ИНТЕРНЭШНЛ




**ЭМНЕСТИ ИНТЕРНЭШНЛ НЬ
ХҮНИЙ ЭРХИЙН ТӨЛӨӨХ
ДАЯН ДЭЛХИЙН ХӨДӨЛГӨӨН.**


**НЭГ Л ХҮНИЙ ЭРХ
ЗӨРЧИГДВӨЛ ЭНЭ НЬ БИД
БҮГДЭД ХАМААТАЙ.**

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Холбоо барих

 info@amnesty.org
mongolia.amnesty@gmail.com

 +44 (0)20 7413 5500
+976 7000 4708

 www.facebook.com/AmnestyGlobal
[www.facebook.com/Amnesty International](http://www.facebook.com/AmnestyInternational)
Mongolia - Монголын Эмнести Интернэшнл

 @AmnestyOnline